

Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ (үлгэрчилсэн загвар)

КЛИРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар

..... оны сарын ...-ны өдөр

Энэ гэрээг

нэг талаас _____ дүүрэг, _____ дугаар хороо, _____, _____ тоот хаягт байрлах _____ (Улсын бүртгэлийн дугаар: _____, регистрийн дугаар: _____) түүнийг төлөөлж _____ албан тушаалтай _____ (цаашид “Тооцооны ерөнхий гишүүн” гэх);

нөгөө талаас _____ дүүрэг, _____ дугаар хороо, _____, _____ тоот хаягт байрлах _____ (Улсын бүртгэлийн дугаар: _____, регистрийн дугаар: _____) түүнийг төлөөлж _____ албан тушаалтай _____ (цаашид “Тооцооны эрхгүй гишүүн” гэх) нар байгуулав.

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээгээр Тооцооны ерөнхий гишүүн тооцооны эрхгүй гишүүнийг төлбөр тооцооны үйл ажиллагаанд зуучлах, түүний нэрийн өмнөөс төлбөр тооцооны үүргийг хүлээхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ гэрээ нь тооцооны үйл ажиллагааны журам бусад холбогдох журам, гэрээгээр хязгаарлагдана.
- 1.3. Энэ гэрээнд ашиглагдсан нэр томъёог Төв клирингийн холбогдох дүрэм, журамд заасны дагуу ойлгоно.

2. ТАЛУУДЫН БАТАЛГАА

- 2.1. Талууд энэ гэрээний хавсралт 1-д заасан үйлчилгээний нөхцөл болон дараах баталгааг гаргаж байгааг харилцан хүлээн зөвшөөрсөн болно. Үүнд:
 - (a) Тооцооны үйл ажиллагааны журам болон эрх бүхий байгууллагаас шаардсан тусгай зөвшөөрөл, эрхийг хуулийн дагуу эзэмшдэг хуулийн этгээд болохыг;
 - (b) Тооцооны гишүүний үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн болон хүний нөөц, техникийн чадамжтай болохыг;
 - (c) Энэ гэрээг байгуулснаар түүний бусад үйл ажиллагаатай харшлахгүй болохыг.
- 2.2. Энэ гэрээний 2.1-д зааснаас гадна Тооцооны үйл ажиллагааны журам, Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан бүхий л баталгааг гаргана.

- 2.3. Талууд энэ гэрээ болон бусад холбогдох журамд заасан баталгааг хангаж чадахгүй болсон тохиолдолд нэн даруй харилцан мэдэгдэнэ.

3. НУУЦЛАЛ

- 3.1. Талууд энэ гэрээний хэрэгжилтийн явцад мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.
- 3.2. Энэ гэрээний хэрэгжилттэй холбоотой хөрөнгө санхүү, ашиг, техникийн холбогдолтой баримт бичиг, мэдээлэл нь нууцлалд хамаарагдах бөгөөд гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.
- 3.3. Энэ гэрээний 3.1. болон 3.2.-т заасныг үл харгалзан Төв клиринг нь түүний тооцооны үйл ажиллагааны журам болон Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журамд заасан шалтгаанаар аливаа нууц мэдээллийг бусдад задруулж болно.
- 3.5. Энэхүү гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш талууд нөгөө талын нууц мэдээллийг 3 жил хадгалах үүрэг хүлээнэ.

4. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 4.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. ...
- 4.2. Талууд энэ гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд гэрээний хувиуд хууль эрх зүйн хувьд ижил хүчинтэй байна.
- 4.3. Талууд гэрээний нөгөө талд 1-ээс доошгүй сарын өмнө урьдчилан бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээг дуусгавар болгож болно.
- 4.4. Энэ гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш ажлын 15 өдрийн дотор талууд хоорондын тооцоог дуусгана.
- 4.5. Энэ гэрээ нь талуудын хооронд урьд өмнө байгуулсан болон цаашид байгуулах аливаа гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд тэдгээр гэрээ нь мөн энэ гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

5. ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 5.1. Энэ гэрээ нь Монгол Улсын хүчин төгөлдөр хууль, тогтоомж болон бусад эрх зүйн актуудын хүрээнд хэрэглэгдэнэ.
- 5.2. Энэхүү гэрээтэй холбоотой үүссэн маргаан, саналын зөрчилдөөнийг харилцан тохиролцож, зөвшилцөх зарчмаар шийдвэрлэнэ.
- 5.3. Талууд зөвшилцөлд хүрээгүй маргааныг МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын “Үнэт цаасны маргааныг шийдвэрлэх түргэвчилсэн дүрэм”-ийн дагуу тус арбитраар шийдвэрлүүлнэ. Арбитрын шийдвэр эцсийнх байна.

6. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

- 6.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.

6.2. Талууд энэ гэрээнд нэмэлт, эсхүл өөрчлөлт оруулсан бол тухайн нэмэлт, эсхүл өөрчлөлтийг хэрэгжүүлэх болон дуусгавар болгох хугацааг тодорхой заасан байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Тооцооны гишүүнийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан:

Тооцооны эрхгүй гишүүнийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан:

Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээний хавсралт.

Тооцооны үйл ажиллагааны нөхцөл

№	Үйл ажиллагаа	Дээд хязгаар	Шимтгэл, хөлс	Хугацаа
1	Тооцооны данс нээх, хөтлөх			
	10 хүртэл данс			Сар бүр
	11-100 хүртэл данс			
	101-500 хүртэл данс			
	501-ээс дээш данс			
2	Позицийн төлбөр гүйцэтгэх			
	Клирингийн шимтгэл			Тухай бүр
	Позици хонуулсан шимтгэл			Хоног тутамд
3	Репо хэлцэл хийх			Хоног тутамд
4	Үнэт цаасны зээлэх			Хоног тутамд
5	Дэнчингийн зээл			
6	1,000,000 төгрөг хүртэл			Тухай бүр
	1,000,001-5,000,000 төгрөг хүрэл			Тухай бүр
	5,000,000 төгрөгөөс дээш			Тухай бүр
	Дефолт торгууль			Тухай бүр